

  
**МОНГОЛ УЛС**  
**ДҮНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**  
**ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 1/39

Мандалговь

Г Сургалтад оролцуулах тухай Г

Монгол Улсын Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.10, Батлан хамгаалахын сайд аймгийн Засаг даргатай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний ажил үйлчилгээ 1.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2022 оны 09 дүгээр сарын 02-ний өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх, дайчилгааны төлөвлөгөөг тодотгох, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг дуулгаваржуулах, орон нутгийн цэргийг зохион байгуулахад сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт мэдлэг, дадлага олгох, тэдний ажилд мэргэжлийн тусалцаа үзүүлэх, цэргийн бэлтгэлийг дээшлүүлэх зорилгоор явуулж буй.govийн бүсийн “Цэргийн бэлтгэл сургалт”-ыг Говьсүмбэр аймгийн Чойр хотод 2022 оны 09 дүгээр сарын 14-17-ны өдрүүдэд зохион байгуулах тул батлагдсан удирдамжийн дагуу сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, үүрэг гүйцэтгэгч нарыг оролцуулсугай.

2. Сургалтад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.  
3. Эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, хөдөлгөөний үеийн аюулгүй ажиллагааны болон бусад холбогдох дүрэм, журмыг сайтар мөрдөж осол авааргүй, оролцохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга (дэд хурандаа Ш.Гансүх)-д даалгасугай.

4. Дээрх арга хэмжээнд шаардагдах 655,776 (Зургаан зуун тавин таван мянга долоон зуун далан зургаа) аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат) нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Энхмарт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ



4822111151